

НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ЖОЛООЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын байрны зорилго

Төслүүдийн хэрэгжилтийг хангах, саадгүй явуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Ажлын байрны зорилтууд

1.Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд болон албан ёсны зочдыг аюулгүй, найдвартай тээвэрлэх;

2.Төслүүдийн хүрээнд бичиг баримт, шуудан, илгээмж хүргэх болон бусад ажлыг цаг тухайд нь найдвартай хүргэж, түгээх;

3. Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн автомашиныг аюулгүй ажиллагааны шаардлагад нийцүүлэн ашиглах, холбогдох дүрэм журам болон төслийн менежментийн дагуу шаардлагыг чанд мөрдөх;

4.Өдөр тутам автомашины тос, ус, аккумулятор, тоормос болон бусад техникийн системийг шалгаж, хэвийн ажиллагааг хангах;

5.Автомашины бүртгэл хөтлөх, бүртгэлд явсан ирсэн цаг, зай, түлш, шатахууны худалдан авалт болон зарцуулалт, хийгдсэн засвар үйлчилгээний бүртгэлийг үнэн зөв хөтөлж, шаардлагатай тайланг гаргах;

6.Атомашиныг өдөр бүр цэвэрлэж, хэвийн байдлыг хангаж ашиглах, шаардлагатай үйлчилгээг хийлгэх;

7. Захиалагчаас өгсөн бусад холбогдох үүргийг биелүүлэх.

Ажлын байранд баримтлах зарчим

1.Хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагааны зохицуулалт, нэгдсэн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналыг нэгжийн түвшинд бүрэн хангах;

2.Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн цар хүрээнд багтах нийт төслийн санхүү, худалдан авалт, тайлан мэдээ, хэрэгжилтийн уялдааг хангах;

3.Шинээр эхлэх төслүүдийн үйл ажиллагааг нэгдсэн нэгжийн бүтэц, зохион байгуулалттай уялдуулан хэрэгжүүлэх бодлогын хүрээг баримтлах.

Ажлын байранд тавигдах шаардлага

1. Жолооны хүчинтэй үнэмлэхтэй байх;
2. Мэргэжлээрээ ажилласан туршлагатай;
3. Замын хөдөлгөөний дүрэм, тээврийн болон аюулгүй ажиллагааны шаардлагын талаар сайн мэдлэгтэй;
4. Төслийн багийн гишүүд болон албан ёсны зочидтой сайн харилцаатай байх;
5. Олон улсын байгууллагын санхүүжилттэй төслүүдэд ажилласан туршлагатай бол давуу тал болно;